



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 688

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 23 нэрийн, нийт 87,718,532.00 (наян долоон сая долоон зуун арван найман мянга таван зуун гучин хоёр) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 27,713,312.90 (хорин долоон сая долоон зуун арван гурван мянга гурван зуун арван хоёр төгрөг ерэн мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг хүлээлцэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



"Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үнэ шинэчлэн тогтоох, ашиглалтын хугацааг сунгах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа /жилээр/	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)
1	Техник жин	2019-02-19	ш	1	2,350,000.00	3	705,000.00
2	Хатаах шүүгээ	2019-02-19	ш	1	1,570,000.00	3	471,000.00
3	Автоклав DSH-280A	2019-02-19	ш	1	685,000.00	3	205,500.00
4	Ус нэрэгч 5л	2019-02-19	ш	1	1,100,000.00	3	330,000.00
5	Лабораторын ширээ	2019-02-19	ш	1	2,800,000.00	3	840,000.00
6	Химийн бодис хадгалах шүүгээ	2019-02-19	ш	1	325,000.00	3	97,500.00
7	Туузан конвейер 232	1991-01-01	м	8	6,151,065.00	3	1,845,319.50
8	Мотор 4кВт * 700 об/мин /к2/	2013-12-31	ш	1	500,000.00	1	50,000.00
9	Хөдөлгүүр 4кВт 750 об/мин /к3/	2013-12-31	ш	1	400,000.00	1	40,000.00
10	Тосон таслуур DW10-70 10кВт	2013-12-31	ш	3	2,305,000.00	2	461,000.00
11	Ширээ 140x80 /ДП/	2012-02-02	ш	2	360,000.00	3	108,000.00
12	Ширээ 120x60 /YA/	2012-04-13	ш	1	120,000.00	3	36,000.00
13	Ширээ 140x80 /ДС/	2012-02-02	ш	1	120,000.00	3	36,000.00
14	Усан ванн	2019-02-19	ш	1	425,000.00	3	127,500.00
15	Вакуум насос	2019-02-19	ш	1	745,000.00	3	223,500.00
16	Шүүх төхөөрөж шилний хамт	2019-02-19	ш	1	765,000.00	3	229,500.00
17	Микроскоп	2019-02-19	ш	1	2,580,000.00	3	774,000.00
18	Булан ширээ 140x140	2011-12-28	ш	4	1,120,000.00	3	336,000.00
19	Ширээ 140x80	2011-12-28	ш	2	360,000.00	3	108,000.00
20	Сандал /дугуйгүй/	2012-03-29	ш	10	1,020,000.00	3	306,000.00
21	Керамик плетка	2014-07-09	ш	1	454,500.00	2	90,900.00
22	Ford Escape машин 75-37 ДАХ, арлын дугаар 1FMCU9DG4CCKA6 5810	2012-11-07	ш	1	60,368,967.00	2	12,073,793.40
23	Автосамосвал Зил-130, 34-53 ДАХ, арлын дугаар М3214782	2021-04-21	ш	1	1,094,000.00	2	8,218,800.00
					87,718,532.00		27,713,312.90
НИЙТ ДҮН					(наян долоон сая долоон зуун арван найман мянга таван зуун гучин хоёр)		(хорин долоон сая долоон зуун арван гурван мянга гурван зуун арван хоёр төгрөг ер)